



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 18 өдөр

Дугаар A/311

Сүхбаатар сум

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг
түр хугацаанд хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 39 дүгээр зүйлийн 39.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 181 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 59 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 01-ний 10 цаг хүртэлх хугацаанд түр хориглосугай.
2. Хориглосон хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, болон гар дээрээс худалдан борлуулсан иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/ нарт тус тус үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумдын Засаг дарга нар, нийт аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx